



ХИЧЭЭЛИЙН АРГА ЗҮЙН САНАА

МОНГОЛ ХЭЛ

(Бага боловсрол)

№ 1, 2019

Энэхүү хичээлийн арга зүйн санаа нь ээлжит хичээлийг төлөвлөх, заах багшийн арга зүйг сайжруулах, сурагчдын сурлагын амжилтыг ахиулах, сургууль, багш нар сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд чиглэнэ.

Сайжруулсан суралцахуйн зорилт: МХЗ. 3.2а. Утга ялгасан үгийг |н,г,х| зөв дуудах, нүдлэх, өгүүлбэрт утга ялган зөв хэрэглэх

Даалгавар:

Цэгийн оронд тохирох үгийг нөхөж бичээрэй.
 “эрх,эрэх”
 Хүүхэд бүр сурч боловсрох, хамгаалуулах тэй.

Сурагчдын гүйцэтгэлийн үр дүн:

Хариулт	Гүйцэтгэл
Хүүхэд бүр сурч боловсрох, хамгаалуулах эрхтэй.	49.9%
Хүүхэд бүр сурч боловсрох, хамгаалуулах эрэхтэй.	50.1%

Сурагчдын даалгаврын гүйцэтгэлд хийсэн шинжилгээ:

Сурагчдын 49.9 хувь нь “эрх” буюу зөв хариулт болох нэр үгийг сонгосон байна. Харин 50.1 хувь нь “эрэх” буюу буруу хариулт болох үйл үгийг сонгосноос үзэхэд:

1. Балархай эгшгийн ялгах үүргийн мөн чанарыг ойлгоогүйгээс
2. Эрх-эрэх “э” балархай ялгах эгшиг нь нэр үгээс үйл үгийг ялгах үүрэгтэй болохыг мэдээгүйгээс буруу хариулсан байх магадлалтай.

Өөрөөр хэлбэл эрх үүргийн эрх, юм эрж хайхын эрэх гэж хүүхэд утгыг ялгаж чадаагүй байна. Багш хичээлийн явцад сурагчдад эдгээр шалтгааны аль нь нөлөөлж байгааг тандаж үзээрэй.

Сурагчдын дээрх алдааг багасгах үүднээс хичээл сургалтдаа хэрэгжүүлэх боломжтой арга зүйн санааг багш нартаа санал болгож байна. Арга зүйн санааг зөвлөхдөө суралцахуйн зорилтын хүрээнд авч үзлээ.




Хичээлийн арга зүйн санааны зорилго: Утга ялгасан үгийг |х| зөв дуудах, нүдлэх, өгүүлбэрт зөв хэрэглэх

Танин мэдэхүйн үйл	Арга зүйн санаа				
Ажиглах, асуудал дэвшүүлэх	<p>Б: Үгсийг ажиглуулан, бичлэгийн хувьд ижил шинжээр нь ялгуулна. (адил төстэй шинжээр нь) Юмсыг ижил шинжээр нь ангилдаг карролын диаграмм ашиглаж болохыг сануулна.</p> <p>С: Эдгээр үгсэд ямар ижил шинж байгааг ажиглаад 2 баганад ангилж бичнэ.</p> <table border="1"> <thead> <tr> <th>Нэрлэсэн үг юу? </th> <th>Үйл хөдлөл заасан үг ях? </th> </tr> </thead> <tbody> <tr> <td> </td> <td> </td> </tr> </tbody> </table>	Нэрлэсэн үг юу?	Үйл хөдлөл заасан үг ях?		
Нэрлэсэн үг юу?	Үйл хөдлөл заасан үг ях?				

Б: Эхний болон хоёрдугаар баганад ямар үгсийг бичсэн байна вэ?
 С: Сурагчид ажигласны үндсэн дээр эхний баганад нэрлэсэн үгс, хоёрдугаар баганад үйл хөдлөл заасан үгс байгааг хэлнэ. Эргэлзэж буй сурагч асуултаар ялгаж болно.
 Б: Дуудлагын хувьд ялгаатай сонсогдож байна уу?
 С: Дээрх хоёр багана дахь үгсийг, хэлж үзээд ялгаа буй эсэхийг харьцуулж хэлнэ.
 • Үгсийг уншихдаа ижил дуудна. Өөрөөр хэлбэл балархай эгшгийг ялгаж уртаар дуудахгүй гэдгийг сануулна.

Мэдээлэл цуглуулах



Б: Дараах зургуудийг ажиглаад, нэрлээрэй.
 С: Зургийг сурагчид ажиглаад нэрлэж бичнэ. савах-савх, харах-харх, сэрэх-сэрх, өрөх-өрх гэх мэт өмнөх мэдлэг дээр тулгуурлан нэрлэж бичнэ.
 Б: Жагсааж бичсэн үгсдээ тодруулах асуулт тавиаарай.
 С: Яах? Юу? гэсэн асуултаар ангилж хүснэгтэд бичнэ

Яах? гэсэн асуултад хариулагдах үйл үгс	Юу? гэсэн асуултад хариулагдах нэр үгс
савах	савх
харах	харх
сэрэх	сэрх
өрөх	өрх

• Хүснэгтэд бичсэн яах? гэсэн асуултад хариулагдах бүх үгийн “х” гийгүүлэгчийн өмнө эгшиг бичигдсэн гэдгийг сурагчдаар ажиглуулсны үндсэн дээр ялгах үүргийг тайлбарлана.

Мэдээлэл боловсруулах

Б: Үгсээс нэгийг сонгоод, утгыг зургаар харуулан бие биедээ тайлбарлаж, жишээ гаргаарай.
 С: Жишээ 1:



	Асуулт?	Ялгаа	Ижил шинж
Өрөх	Яах?	Балархай эгшигтэй	Дуудлага
Өрх	Юу?	Балархай эгшиггүй	Дуудлага

- Өрөх – алаг мэлхий өрөх буюу үйл хөдлөлөөр илэрч байна. Өрх – гэрийн өрх буюу нэр үгээр илэрч байна. Үүнээс харахад дуудлагын хувьд ижил ч утга, бичлэгийн хувьд ялгаатай байна.
- Өрөх, сэрэх, харах гэсэн үгсийн “-х” гийгүүлэгчийг үйлт нэрийн “х” гэж нэрлэдэг. Яагаад ингэж нэрлэсэн юм бол? Үйл хөдлөл зааснаас болсон уу? Ямар нэгэн зүйлийг нэрлэж байгаагаас болж байна уу? Зөв хариулт нь, үйл хөдлөлийг зааж байгаа учраас үйлт нэрийн “-х” гэж нэрлэдэг гэсэн дүгнэлт хийнэ.
- Үйл хөдлөл илэрхийлсэн үгийн “х”-г нэрлэсэн үгээс ялгахын тулд балархай эгшиг бичнэ.

Мэдээллээ хэрэглэх

• Сурагчид үйл хөдлөл заасан үгийн “х”-г нэрлэсэн үгээс ялгахын тулд холбоо үгийг зөв бүтээх, цэгийн оронд тохирох үгийг нөхөх, өгүүлбэрийг гүйцээх, утгыг тайлбарлах, утгад тохирох үгийг сонгох, өгүүлбэр зохиох гэх мэт олон боломжит дасгал, дадлага ажлаар мэдлэгээ хэрэглэнэ. Жишээ нь:

Жишээ 1: Холбоо үгийг зөв бүтээх

1.үндэстэн, наранд|халх, халах|
2. эрх, ногоо|дарх, дарах|

Жишээ 2: Цэгийн оронд тохирох үгийг нөхөж өгүүлбэрийг гүйцээх
 |сэвх, сэвэх, чимх, чимэх |

1. А. Буузыг сайн ёстой.
 Б. Нүүрний яаж үүсдэг вэ?
2. А. Хоолонд давс нэмээрэй.
 Б. Хүүхдүүд гацуур модоо дуртай.

Дүгнэлт хийх

Зулаагийн алдааг засаарай

Торохтой зөгийн балыг харсан уу? Алаг мэлхийг зөв өрхийг сурлаа. Өглөө эрт сэрхийн тулд эрт унтах ёстой. Хичээл завсарлаж хонох дуугарлаа. Утас удаан харах нүдэнд хортой. Ээж надад дээл хавх оёдлыг заалаа.

- Утга ялгасан алдаатай үгсийг ялгаж бичнэ. /торохтой, өрхийг, сэрхийн, хонох, хавх/
- Алдаатай бичигдсэн үгийг залруулж бичнэ. /торхтой, өрөхийг, сэрэхийн, хонх, хавах/
- Эдгээр үгсийг яагаад ингэж бичсэн шалтгаанаа тайлбарлана.

Үүнээс үйл үг заасан үгээс утга ялгахын тулд балархай эгшигтэй бичиж байна. Үйл үгийн “х” залгаврын өмнө орсон эгшгийг гээхгүй бичнэ гэсэн дүгнэлтийг хийнэ.

Багшид зориулсан нэмэлт зөвлөмж:

- Дээрх суралцахуйн зорилт нь бичих чадварын суралцахуйн зорилт бөгөөд 2, 3, 4, дүгээр ангийн бичихийн эхний |а| зорилтууд нь агуулгын залгамж холбоотой байгааг анхаарч, хичээлээ төлөвлөх нь сурагчдын мэдлэг, чадварын гүйцэтгэлд нөлөөлөх болно.
- Ялгах үүргийг дасгал, дадлага ажлаар дамжуулан ойлгуулах бөгөөд хэлний дүрэм талаас хоосон цээжлүүлэхийн оронд жишээ баримт, зүй тогтлыг ажиглуулах, харьцуулах, сурагчдаар өөрсдөөр нь бүтээлгэх, хэрэглэх байдлаар учрыг нь ойлгуулах нь чухал.
- Асуудлыг дэвшүүлэх, мэдээллийг цуглуулж, боловсруулахад нь сурагчдыг багаар, хосоор ажиллуулж, санал солилцох, бие биеийнхээ ярьж тайлбарласныг сонсох боломжийг багш олгож, хамтран суралцахуйг дэмжээрэй.

Эх сурвалж: БХ., (2019) ., “ЕБС-ийн сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн нөхцөл байдлын судалгаа”. УБ.

Боловсруулсан: Д.Ганчимэг